



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 96

Эрдэнэт

**“Хөх Монгол цогцолбор” ОНӨААТҮГ-ын төлөөлөн
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3.к дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Хөх Монгол цогцолбор” ОНӨААТҮГ-ыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлд ДААЛГАХ нь:

2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг батлуулах.

2.2. Гүйцэтгэх захирлын эрх хэм хэмжээг дүрэм, ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж, зардлын дээд хязгаар, өмч хөрөнгө, санхүүгийн нөөц зарцуулах эрхийг тогтоон хяналт тавин ажиллах.

2.3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, өр авлага бууруулах талаар гүйцэтгэх захирлын хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр хэлэлцэж байх.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 50 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

C: / Togtool / -A4 doc

0010284